

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Циенхүүгийн Дашдорж	Дугаар	L009
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Дундговь аймгийн Сайхан-Овоо сум	Төрсөн он	1908
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хутагт ламын хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 016
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	УВ 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хутагт ламын хийд

Би 5 настайдаа лам болж 30 хүртлээ лам байсан. Анх лам болоход хийдээс хойхно жижигхэн суурин байсан юм. Тэнд лам болоод байтал багшийн гал тогоог барьдаг хүн шарлаад нэг орой бууз хийж идээд хоносон. Өглөө нь гал тогоо барьдаг хүний нүд нов ногоон болчоод босоод ирсэн. Багш минь сандраад хүний нялх хүүхдэд халдаачихна гээд. Тэгээд манайх намайг аваад явсан. Онгийн голын тэнд малаа услах гээд явсан. Ирээд багш чинь нисээд явчихжээ л гэсэн. Яаж байгаад нисчихэвээ. Мандал овоон дээр гараад нисчихэв үү, дуган дээр гараад нисчихэв үү гээд би шалаад байсан. Тэгснээ багш маань нас барчихсан байж. Манайх нүүж буулаа. Цагаан сар боллоо. Манай

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

эжийгийн ах лам байсан. Тэгсэн эжийгийн ах Хутагт ламын хийдэд Цагаан хөмсөгт Жигмэддорж гэж байдаг. Түүнд аваачиж өг гэж байна гэсэн. Миний ах ээжийн ах ламд шавь орсон байсан юм. Эхнийх нь гараас гараагүй байхад би чадахгүй гээд тэр Цагаан хөмсөгтөд аваачиж өг. Ном эс сурахнаа ч мал малллаж сураг гэсэн юм байна лээ. Тэр Цагаан хөмсөгт гэдэг нь мал ихтэй баян хүн байсан. Тэгээд тэднийд 10 хүртлээ байгаад хийдийн бараа харсан. Хадны усны сүмд 4, 5 жил суусан. Тэгээд 30 хүртлээ Хутагт ламын хийдэд сууж байсан. Донч Лхүндэвийн гэгээн гэдэг хүн эхэлж байгуулсан гэдэг. 4 дэхь дүр нь гэж байсан. Одоо байгаа бол 101-тэй хүн байх байсан. Чойр, Манба, Жүд, Дүйнхор гэсэн 4 дацантай. Цамтай, Майдартай байсан. 200-аад ламтай байсан.

Анх Чойжид үздэг. Дараа нь хэнгэрэг цантай уншдаг Хангал үзсэн. Гүнрэг үзсэн. Чойрт 27-тойдоо домын дамжаа барьсан. Цамтай газар байсан. Цамд 4 жил гарч байсан. Хамгийн анхны жил Шамба ниржиг гэж Улаан сахиусны хорд, Чадраабалд, дараа Ямандагт, хамгийн сүүлд майхан домбромбын дүрд гарч байсан. Нийтдээ хоёр өдөр гарна. Цамд нийдээ 70-аад дүр гарна. Зуны дунд сарын шинийн 8, 9-нд гарна. Шинийн 8-нд Хийдийн гол сахиус Жамсран сахиусны 33 дүр гарна. 9-нд бүтнээрээ гарна. 21 шанага, Гомбо 5-уул, Лхам 3-уул, Чойжоо 2, 3 Ядам, Сэндом 3, Жамсран 3 гээд 60 орчим юм гарна. Хийдийн нэрийг Төвдөөр Дашцэмпэл гэж нэрлэдэг байсан.

Онгийн гурван хийд гэж байсан. Урд хийд нь Хутагт ламын хийд. Мэлхий товог гэдэг нэртэй дэнж дээр байсан. Хойд хийд нь хадан дотор байсан. Хойд хийд нь Хамба ламын хийд. Барь лам Дамцагдоржийн хийд. Хойд хийдийн ноён уулын Бумбат гэнэ. Сэндомын хад гэж байсан. Зүүн тийшээ Цагаан толгой, Майхан хүрэн гэж байсан. Баруун өмнө байсан Шаширын овоог тахидаг байсан. Хаврын адаг сарын 2-нд Шаширын наадам болно. Хойшоо Цоржийн ам гэж байсан.

Гол шүтээн нь Баруун, Зүүн сахиус. Баруун сахиус нь Янсан ядам. Зүүн нь Жамсран. Дацан тус бүр сахиустай. Жүдийнх Сандэжигсүм. Чойрынх арван Хангал, Майдар. Дүйнхорынх Дүйнхор. Майдарынх Майдараа шүтнэ.

Манайд Түшээт хан аймгийн Говь Түшээ гүний хошуунаас ихэвчлэн ирж сууна. Хошууны ноён Лхамсүрэн гэж байсан.

Зураач Дашдорж гэж байсан. Чимэд маарамба гэж эмч байсан. Чойжамц гэж эмч байсан.

Дуганууд нь дандаа төвд маягийн гэр дуган байсан. Хийдээс урагшаа 50-60 м-н зайтай Хутагт ламын өөрийнх нь суудаг Лаврин гэж байсан. Байшин хашаатай тусгай хэдэн байшин байдаг байсан.

Өдөр бүр Цогчэнтэй. Цагаан сарын 23-нд Сайхан сахиус гэж Гомбо, Жамсран хурна. Хаврын дунд сарын 10-15 хүртэл Янсан Ядам хурна. Хаврын адаг сарын шинийн 2-26 хүртэл Дүйнхор хурна. Хурлаа эхлэхэд дүлцон хийнэ. Сагар гэж гараад 15-нд дүлцонгоо дуусаад Дүйнхороо эхлэхлээр Чогор гэж гарна. Чойрт намрын дамжаа намрын дунд сарын шинийн 3-нд гавжийн дамжаа барина. Өвлийн дунд сарын 20-нд домын дамжаа барина. Жил өнжиж барина. Жүд ч 4 цагт л хурж байдаг. Зуны дунд сарын шинийн 5-нд сарын ерөөл гэж хурна. Шинийн 5-нд орой Жанлав гэж хурчихаад шинийн 6-аас 15-г шувтаргал 10 хоног сарын ерөөл гэж хурна. Сарын ерөөлөө хурчихаад 16-нд Майдараа эргэнэ. Орой нь цамынхаа дэгийг эхэлнэ. 16-22 хүртэл бага дэг гэж хийнэ. Өглөө цуглаад Чойжоо гэдэг ном

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хураад хэнгэрэг цантай дэгээ хийнэ. 22-нд Барь ламын хийд Майдараа эргэнэ. Тэр орой урд хийдэд их дэг гэж бүрээтэй хийнэ. Тэгээд дэгээ хийсээр байгаад шинийн 2-нд Сайхан Гомбо хурна. Шинийн 6, 7-нд гоё дэг гэж хийгээд шинийн 7,8-нд цам гарна. Зулын 25-нд өглөөнөөс эхлээд орой хүртэл хурна. Зуны адаг сард Говийн молон гэж 3 өдөр хурна. Чойжид гэдэг ном уншина. Жисаа Ганжуур гэж 3 өдөр уншина. Сүүлийн өдөр Ганжуураа бариад хүрээгээ горооны замаар эргэнэ. Цамаас өмнөхөн гардаг байсан. 108 боть ном байна. Хайлантай байсан. Хайлан хийж байгаа хүн горооноос гарахгүй. Нүгнээ сахидаг байсан.

Хийдийн гадаад байдал нь төвд маягийн. Дугануудын өнгө нь цагаан. Шохойдсон байсан. Элдэв янзын гоёлтой байсан. Маарамбын дамжаа хошуу хийдэд барьдаг байсан. Чойрын сургалт нь Гүнчэн ламын игчаатай байсан. 7 зиндаатай байсан. Төвд лам байгаагүй. Харин Төвд рүү явж сурч байсан байх аа.

Дуган бүр жастай байсан. Жас нь мал ихтэй, багатай янз бүр байсан. Цогчэн жас мал ихтэй байсан. Манай аав, ээж жасын мал маллаж байсан.

Сүм хийд сүүлдэ миндаг тушаалаараа татвар төлдөг болсон. Би 30 төгрөгийн татвар төлж байсан. Хөрөнгө чинээ, миндаг тушаалаараа төлж байсан.

Ваниндорж гэж лүйжинч байсан. Олон шавьтай. Чойрын шунлайв нь Дэчин гэж байсан.

Тэр үеийн лам нар хурлаа л хурдаг байсан. Хурал номын үед сүсэгтнүүд очно. Хүрээн дотор эмэгтэй хүнийг оруулдаггүй байсан. Хийдийн ойролцоо хятад наймаа байсан.

Хийд үхэр жил хаагдсан. Хэдэн оныг мэдэхгүй. Гуулин бурхан эд нарыг нь Хүрээ рүү л ачаад явсан байх.

Би 1990 оноос хойш Дашчойлинд хурж байна.